

2022 оны 9 сарын 30

ARD СЕКЮРИТИЗ  
ҮЦК

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



## ОНЦЛОХ МЭДЭЭ

- Баавгай эргэж ирлээ. Зах зээл дээр ёроол ханш тогтож байгааг харуулсан 3 шинж тэмдэг
- Хөрөнгийн зах зээл эдийн засгийн хямралтай нүүр тулах нь тодорхой болсноор шинэ нөхцөл байдал үүслээ
- Доллар чангарснаар бусад гадаад валют унасан. Жишээлбэл, фунт хүчтэй унасан.

2022.10.03-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	28,783.00	0.19%	-1.64%	-8.45%	-15.36%
US500	3,586.73	0.00%	-1.85%	-8.58%	-17.92%
NASDAQ	10,922.04	-0.45%	-2.88%	-9.88%	-24.48%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	6,894.00	0.18%	-1.78%	-5.36%	-1.90%
DE40	12,114.00	1.16%	-1.38%	-5.61%	-20.07%
FR40	5,762.00	1.51%	-0.36%	-5.92%	-11.59%
IT40	20,649.00	1.45%	-1.98%	-4.22%	-19.39%
ES35	7,367.00	0.91%	-2.86%	-6.59%	-16.28%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	26,078.00	0.87%	-1.22%	-5.44%	-8.22%
SHANGHAI	3,024.00	-0.55%	-2.07%	-5.55%	-15.81%
CSI 300	3,805.00	-0.58%	-1.33%	-6.72%	-22.82%
SHANGHAI 50	2,610.00	-0.04%	-0.75%	-5.49%	-19.84%
CH50	12,908.25	-0.37%	0.09%	-4.90%	-18.39%
SENSEX	57,427.00	1.80%	-1.16%	-2.28%	-2.28%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	81.79	2.89%	6.69%	-7.82%	5.44%
Газрын тос (Brent)	87.28	2.49%	5.39%	-7.49%	7.47%
Байгалийн хий	6.66	-1.42%	-5.07%	-23.89%	15.48%
Шатахуун	2.42	2.17%	5.82%	-2.31%	4.91%
Нүүрс	433.70	-0.47%	-0.34%	2.05%	90.22%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,664.41	0.29%	2.66%	-2.66%	-5.92%
Мөнгө	19.20	1.06%	4.75%	5.75%	-15.24%
Зэс	3.40	-1.14%	2.64%	-1.12%	-19.86%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.7823	-0.0217	-0.10%	0.56%	2.30%
Англи	4.0920	-0.0460	0.26%	1.29%	3.09%
Швейцар	1.2370	-0.0730	-0.12%	0.38%	1.42%
Испани	3.3000	-0.0860	0.10%	0.56%	2.87%
Герман	2.1090	-0.0990	0.08%	0.57%	2.33%



## **Баавгай эргэж ирлээ. Зах зээл дээр ёроол ханш тогтож байгааг харуулсан 3 шинж тэмдэг**


### **Хөрөнгийн зах зээл эдийн засгийн хямралтай нүүр тулах нь тодорхой болсноор шинэ нөхцөл байдал үүслээ**

АНУ-ын төв банкны мөнгөний бодлогын хурлаас хойш хэдэн 7 хоногт хөрөнгийн зах зээл ихээхэн хэлбэлзэлтэй байлаа. S&P 500 индекс он гарснаас хойш 23%-ийн уналттай байгаа нь баавгайн зах зээл үргэлжилсээр байгааг харуулж байна. Хэдийгээр шинжээчид хатуу мөнгөний бодлого баримталж буй үед эдийн засаг хямрахгүй даван туулчих болов уу гэж харж байсан боловч одоогийн зах зээлийн ханшаас харахад хямралд ороход тун ойрхон байна.

Хямралын талаар олон шинжээчид анхааруулж байсны нэг нь ХНС-ийн ерөнхийлөгч Жером Пауэлл байсан. Тэрээр бодлогын хүүг өсгөх тусам хямралыг тойроод гарах бэрхшээлтэй болно гэж сануулсан. Одоогоор бидний гол анхаарлаа хандуулах зүйл эдийн засаг хэр хүчтэй, гүн хямрахыг ажиглах үлдлээ.

Хэрвээ нэмж урьдчилан таамаглашгүй зүйл тохиолдохгүй бол АНУ-ын эдийн засаг тийм ч гүн хямралд орохгүй болов уу гэж шинжээчид үзэж байна. Хөдөлмөр болон санхүүгийн зах зээл тогтвортой, бусад улсуудыг бодвол эрчим хүчний шоконд их орохооргүй байгаа нь эдийн засаг харьцангуй тэсвэртэй байж магадгүй. Өнгөрсөн 7 хоногт Английн төв банк хөрөнгийн зах зээлээ дэмжихийн тулд нэмэлт санхүүжилт олгохоо мэдэгдсэн.

## Хямрал тохиох магадлал одоогоор 67%-тай байна



## Бага зэргийн эдийн засгийн хямралтай үед хөрөнгийн зах зээлийн өгөөж хэр сайн байсан юм бэ?

Мөчлөг болгон харилцан адилгүй байдаг ч өмнөх хямралуудаас өгөөж хэр байсныг харж болно. Өнгөрснөөс харахад хөрөнгийн зах зээл ойролцоогоор 25%-35%-иар унаж байсан ба 10-15 сар үргэлжилсэн. Харин сэргэлтийн хугацаа 9 сараас 2 жил хүртэл үргэлжилж байсан. Гүн хямралаар уналтын хувь болон үргэлжлэх хугацаа хоёр дахин ихэсдэг ч энэ нь ихэвчлэн системийн асар том гажуудлаас болж үүсдэг. АНУ-д одоогоор ийм гажуудал үүсээгүй байгаа ба зах зээл аль хэдий нь ээ 20% уначихсан байгаа нь уналт дуусах дөхөж байж магадгүй.

## Зах зээлийн ёроол тогтож буй процессыг харуулах 3 шалтгаан

Ойрын хугацаанд эдийн засаг унаж магадгүй ч хөрөнгийн зах зээл ирээдүйг харж байдаг тул нөхцөл байдал муудаж байсан ч сэргэлт үзүүлж байх боломжтой юм. Хөрөнгө оруулагчдын одоо гол асууж байгаа зүйл бол “зах зээлийн ёроол үүсэж байгаа эсэхийг мэдэхийн тулд юуг харж байх хэрэгтэй юм бэ?”



Зах зээлийн доод болон дээд ханш хэзээ тогтохыг мэдэхэд их хэцүү байдаг. Илүү туршлагатай шинжээчид хөрөнгийн зах зээлд яг хэзээ орох нь чухал биш, хэр удаан орох нь чухал гэдэг. Гэсэн хэдий ч ёроол тогтож байгаа эсэхийг мэдэхийн тулд дараах 3 зүйлсийг хянаж байх хэрэгтэй.

1. Инфляцын бууралт. Хэрэглээний үнийн индекс 40 жилийн дээд цэгтээ хүрснээр инфляц зах зээлд учирч буй хамгийн том асуудал байсаар байна. ХНС болон бусад улсын төв банкнууд мөнгөний бодлогын шийдвэр гаргахдаа инфляцыг хамгийн чухалчилж харж байна. ХНС аль хэдий нь инфляцыг тогтмол буурсны дараа л бодлогын хүүг нэмэхээ зогсоохоо мэдэгдсэн. Энэ нь инфляцыг 3-4 сар тогтмол буурах шаардлагатайг хэлж байгаа юм. Хэрвээ инфляц ингэж буурах юм бол хөрөнгийн зах зээл тогтмол өсөх боломжтой.

Сайн мэдээ нь инфляц буураад эхэлсэн. Газрын тосны ханш 6 сарын үеэс хойш унасаар байгаа ба бензиний үнэ бас буурч байгаа. Нийлүүлэлтийн гинжин хэлхээ, инфляцын хугарлын цэг, төсөөлж буй инфляцын түвшин бүгд буурах хандлагатай байна. Ганц өсөж байгаа зүйл бол суурь инфляц, тэр дундаа орон сууцны үнэ унаагүй хэвээрээ байна. Орон сууцны зээлийн хүү 7% руу ойртож, 30 жилийн дээд хэмжээнд хүрээд байгаа нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг цаашид унах болов уу гэж харж байна.

**Түүхий газрын тос болон S&P таваарын индекс хоёулаа унасаар байна**






- Бондын өгөөж унаж эхэлсэн. 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойш бондын өгөөж харьцангуй тогтмол, зарим үед тэг хувь бараг хүрч байсан. Үүний ачаар санхүүгийн зах зээл, тэр дундаа хөрөнгийн зах зээлд компаниуд хямд зээл авч, эрсдэл хүлээх чадвар өндөр байсан.

2022 он гарснаас хойш төв банкнууд бодлогын хүүгээ өсгөснөөр бондын өгөөж өссөн. 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 1.5%-иас 4.0% хүртэл өссөн. Өгөөж өссөнөөр өндөр үнэлгээтэй байсан компаниудын хувьцааны ханш их унаж эхэлсэн.

Хэрвээ 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж буурах юм бол хөрөнгийн зах зээлд ёроол тогтох нэг шалтгаан болно. Бондын өгөөж тогтворжсоноор ХНС-ийн хатуу мөнгөний бодлого дуусах дөхөж байгааг илтгэдэг.

## 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж энэ жил 4.0% хүртэл өссөн



3. Долларын ханш сулрах. Ам.долларын ханш он гарснаас хойш 17% өсөөд байгаа бол 2021 оны эхээс 25% өссөн. Энэхүү өсөлтөд нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйлс байгаа боловч гол шалтгаан нь АНУ-ын эдийн засгийн нөхцөл байдал бусад улсуудынхаас сайн байгаа ба ХНС илүү хурдтай бодлогын хүүгээ өсгөж байгаагаас болсон. Олон улсын эдийн засаг унаж байгаа үед доллар хамгийн найдвартай гэж хөрөнгө оруулагчид харж байна.

Олон улсын зах зээлд хүндрэлтэй тулгарснаар, томоохон гадаад валютуудын ханш долларын эсрэг хүчтэй суларсан. Доллар чангарснаар хурдтай хөгжиж буй эдийн засгийн индекс энэ жил 30%-иар буурсан. Нэмээд АНУ-ын экспортын бараа илүү үнэтэй болсон. Иймд, долларын ханш тогтворжиж, цаашлаад унаснаар зах зээлд ёроол тогтоно.

Доллар чангарснаар бусад гадаад валют унасан. Жишээлбэл, фунт хүчтэй унасан





**Баавгайн зах зээлээр 20% болон түүнээс дээш уналт тохиодог боловч ирэх жилийнх нь өсөлт бүр хүчтэй байдаг**

Хөрөнгийн зах зээл энэ жил амаргүй байсан ч уналт эхлэхээсээ илүү төгсгөлдөө орсон гэж үзэж байна. Шинжээчид одоо инфляц, бондын өгөөж, долларын ханш гурвыг ойроос харснаар зах зээлийн ёроолыг тогтсон эсэхийг мэдэх боломжтой болно. Дашрамд дурдахад, шинжээчид энэ удаагийн сэргэлтийг хүчтэй “V” сэргэлтээс илүү удаан үргэлжилсэн “U” хэлбэртэй байна гэж төсөөлж байна.

Сайн мэдээ гэвэл, 1935 оноос хойш S&P 500 индекс 1 жилийн дотор 20%-иас дээш унасан тохиолдолд дараагийн жил нь дунджаар 25% өссөн байна. Иймд, урт хугацааны хөрөнгө оруулагчдад хямд үнэтэй сайн хувьцаа авах завшаан тохиож байгаа юм.